



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

“Азиа пасифик секьюритис ҮЦК” ХХК-ийн
үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 63 дугаар зүйлийн 63.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Азиа пасифик секьюритис ҮЦК” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсонтой холбогдуулан компанийн тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж шинэчилсэн дүрмийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, хувийг ажлын 10 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Азиа пасифик секьюритис ҮЦК” ХХК /Н.Батжин/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН